

БАТЛАВ:

НИЙСЛЭЛИЙН ЗАМ, ТЭЭВРИЙН
АСУУДАЛ ХАРИУЦСАН
ТӨСЛҮҮДИЙН УДИРДАГЧ

Б.ОТГОНСҮХ

ЗӨВШӨӨРСӨН:

НИЙСЛЭЛИЙН АВТО ЗАМЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА

Ж.ТОГТОХБАЯР

1110265139 9115064

НААДАМЧДЫН ГУДАМЖИНД БАЙРЛАХ ГҮҮРНҮҮДИЙН ӨРГӨТГӨЛИЙН АЖЛЫН
НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

Дугаар 34-19/103

1. Зураг төсөл зохиох үндэслэл: > Нийслэлийн Засаг даргын 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/745 дугаар захирамж
2. Байршил: Хан-Уул дүүрэг, 4, 5, 6, 8 дугаар хороо,
3. Гүүрээр нэвтрэх авто замын техникийн зэрэг: Гол гудамж зам
4. Гүүрийн бүтээц: Тооцоогоор үндэслэнэ. Хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын техникийн нөхцөлийг хангаж, тээврийн хөдөлгөөнийг саадгүй нэвтрүүлэх боломжийг хангах зорилгоор барих.
5. Газрын бартаалаг, төвөгшил: Трасс сонголтын үеийн болон замын төсөллөлтийн төвөгшлийг БНБД-ээс харах
6. Зураг төсөл зохиох үе шат, хугацаа: 1 үе шаттай 2019 он
7. Захиалагч байгууллага: Нийслэлийн Авто замын хөгжлийн газар
8. Зургийн байгууллага: Авто зам, гүүрийн зураг төслийн тусгай зөвшөөрөлтэй байгууллага
9. Барилгын гүйцэтгэгч байгууллага: Авто зам, гүүрийн барилгын төслийн тусгай зөвшөөрөлтэй байгууллага
10. Хөрөнгийн эх үүсвэр: Нийслэлийн замын сангийн хөрөнгө

11. Онцгой нөхцөл:

- Гүүрийн зураг төслийг Авто зам, замын байгууламжийн зураг төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам, “Ачаалал ба үйлчлэл /БНБД 2.01.07-90/”, “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх /БНБД 22-01-01/”, “Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм /БНБД 30.01.04/”, “Авто зам төсөллөх” ЗЗБНБД 22-004-2016 “Авто замын гүүр ба хоолой төсөллөх БНБД 32-02-12 болон бусад холбогдох норм дүрмүүдийг үндэслэнэ.
- Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага, Чингэлтэй нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөж НХБХГ, НАЗХГ-тай үе шаттайгаар санал солилцох, зөвшилцөх
- “Геодези зураг зүйн тухай” хуулийн 6.1.3 дугаар заалт, “Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл” БНБД 11-07-04-ын II хэсэг инженер геодезийн ажил, “Геодезийн ажил “БНБД 3.01.03-88-д тавигдах шаардлагын дагуу зураг төслийг боловсруулах.
- Хэмжилт зураглалын ажлыг улсын сүлжээний цэгүүдэд UTM системд тулгуурлан хийх, геодези, байр зүйн зураглал хийж, ажлын иж бүрэн тайланг зураг төслийн шатанд хянуулж хүлээлгэн өгөх
- Гүүр баригдах газрын цаг уурын нөхцөл, ус зүйн судалгаа, инженер геологи геотехникийн үзүүлэлтүүдийг нарийвчлан гаргаж тайлан боловсруулах, дээрх үзүүлэлтүүдийг үндэслэн захын тулгуурын байрлал, буурь суурийн төрөл, хийцийг бат бэхийн тооцоогоор оновчтой тодорхойлон сонгох.
- Гүүрийн өргөтгөлийг Нийслэлийн Нийтийн тээврийг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсөл-1-ийн хүрээнд ТЗА-ны буудлуудын хооронд 2 эгнээ шулуун замыг Наадамчдын замын тусгаарлах зурвас дээр шинээр барих ажлын зураг төсөлтэй уялдуулан зураг төслийг боловсруулах.
- Гүүрийн загвар, хийцийг хүрээлэн буй орчинтой зохицуулж өнгө үзэмж сайтай, архитектурын шинэ шийдлээр төлөвлөн гүүрийн эскиз зургийг НХБХГ, НАЗХГ-тай үе шаттайгаар санал солилцон зөвшилцөх
- Гадаргуун ус зайлуулалтыг тухайн зам, гүүрийн хэсэг орсон ус хураах талбайн хэмжээнд тооцоо хийж төлөвлөх.
- Зургийн ажлын явцад инженерийн шугам сүлжээний байгууллагуудын тодруулга, техникийн нөхцлийг авч, шугам сүлжээний ажлын зураг боловсруулах, магадлалаар батлуулах, бусад холбогдох байгууллагуудтай зөвшилцөх.


- Гүүрийн баруун талд явган хүн болон дугуйтай зорчигч зэрэг явах боломжтой зам төлөвлөх ба хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан хайс, хашлага /байгалийн чулуу/, авто машинаас тусгаарлах эд анги нарийвчлан тусгах.
- Хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган тэмдэг, тэмдэглэгээ, хөдөлгөөн зохицуулалтын тоноглолыг иж бүрэн байдлаар зураг төсөлд тусгах
- Гүүрийн үндсэн элементүүд болох зорчих хэсэг болон хөндөгдөж буй шугам сүлжээ зэргийг хамруулан ажлын зургийг иж бүрнээр төсөллөх.
- Цементбетоны хүйтэн тэсвэрлэлтийг Монгол орны цаг уурын нөхцөлд тохируулах.
- Гүүрийн өргөтгөлийг одоо байгаа гүүрийн даацад нөлөөлөхөөргүй байдлаар төлөвлөх
- Гэрэлтүүлгийн төлөвлөлт хийж, хүчин чадлыг тодорхойлсны дараа тухайн зөвлөх нь “Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ” ХК руу бие даан хандаж /өргөдлийн маягт бөглөх/ техникийн нөхцөл авч /эх үүсвэрийг заалгах/ ажлын зургийг боловсруулах.
- Зураг төслийг дараахь масштабтайгаар боловсруулна. Үүнд:

- Дэвсгэр зураг	1:500
- Дагуу огтлол	хэвтээ 1:2000
	босоо 1:200
- Хөндлөн огтлол	1:100
- Уулзвар, огтлолцол	1:500
- Бүтээц	1:20
- Хэсэглэл	1:10
- Зураг төслийн тайлбар бичиг болон бүрдэлт:
 1. Гүүрийн байгууламжийн ажлын зураг
 2. Инженер геологийн дүгнэлт
 3. Геодезийн ажлын иж бүрэн тайлан
 4. Инженерийн шугам сүлжээ, гэрэлтүүлгийн ажлын зураг
 5. Техникийн шаардлага
 6. Тайлбар бичиг
 - (1) Төсөллөж буй гүүрийн танилцуулга, төслийн шийдэлд онцгой нөлөө үзүүлэх аливаа хүчин зүйлсийн талаархи мэдээ
 - (2) Гүүрийн бат бэхийн болон буурь, суурийн тооцоо


- (3) Тухайн байршил орчмын байгаль цаг уурын статистик мэдээ, төслийн шийдэлд онцгой нөлөө үзүүлэх аливаа байгаль цаг уурын хүчин зүйлсийн тухай мэдээ
- (4) Гүүрийн барилгын ажлын тоо хэмжээ
- (5) Холбогдох техникийн нөхцлүүд
7. Хяналтын төсөв / зах зээлийн өнөөгийн үнэ болон мөрдөгдөж буй норм үнэлгээний дагуу боловсруулна./
- Гүүрийн ажлын зураг, тайлбар бичиг, инженер геологийн дүгнэлт, геодезийн ажлын тайлан, инженерийн шугам сүлжээний ажлын зураг, холбогдох бичиг баримтыг эх хувь 1ш, хуулбар хувь 3ш (хуулбар хувийг өнгөтөөр хувилж авчрах), тоон хэлбэрээр /DWG болон PDF/ хүлээлгэж өгнө.

Хянасан:

НАЗХГ-ын орлогч дарга

 /Б.Индра/

НАЗХГ-ын Бодлого зохицуулалтын хэлтсийн
Ахлах мэргэжилтэн


 /Б.Анхбаяр/

Боловсруулсан:

НАЗХГ-ын Бодлого зохицуулалтын хэлтсийн
инженер шугам сүлжээний мэргэжилтэн

 /Т.Чингэс/

НАЗХГ-ын Бодлого зохицуулалтын хэлтсийн
мэргэжилтэн

 /Б.Ертис/

2019 оны 09 сарын 09

НИЙСЛЭЛИЙН АВТО
ЗАМЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР

Газрын байршил

Газрын зориулалт

Хан-Уул дүүрэг, 4,5,6,8-р хороо

Гүүр





Таних тэмдэг



Тусгай замын автобусны трасс

Хянасан:
НАЗХГ-ын БЗХ-ийн ахлах мэргэжилтэн
Боловсруулсан:
НАЗХГ-ын БЗХ-ийн мэргэжилтэн


...../Б.Анхбаяр/

...../Б.Ертис/